БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2025/002/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Еркебулан<br>Утас: 99427667 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 3
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 16
**4.1 Ерөнхий зүйл** ........ 16
**4.2 Материаллаг байдал** ........ 16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 17
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 17
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 17
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 17
**5.1 Төлбөрийн акт** ........ 17
**5.2 Албан шаардлага** ........ 18
**5.3 Зөвлөмж** ........ 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 18

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 3
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 16
**4.1 Ерөнхий зүйл** ........ 16
**4.2 Материаллаг байдал** ........ 16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 17
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 17
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 17
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 17
**5.1 Төлбөрийн акт** ........ 17
**5.2 Албан шаардлага** ........ 18
**5.3 Зөвлөмж** ........ 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2025.02.17 № 43

танай ____________-ны № ____________-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЕРХАНАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Шүүхийн тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

Шүүхийн тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газрын Дүгнэлт

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,979,700.00** | **13,386,960.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 10,600,000.00 | 7,489,500.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 10,600,000.00 | 7,489,500.00 |
| **3121** | **Төгрөг** | 10,600,000.00 | 7,489,500.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,600,000.00 | 7,489,500.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,379,700.00 | 5,897,460.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,379,700.00 | 5,897,460.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 44,000.00 | 164,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,163,000.00 | 4,561,660.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 172,700.00 | 1,171,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **419,956,474.57** | **571,799,078.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 419,956,474.57 | 571,799,078.99 |
| **392** | **Биет хөрөнгө** | 397,639,720.28 | 544,534,078.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 277,252,330.00 | 277,252,330.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (72,419,249.86) | (86,990,032.18) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 159,000,000.00 | 85,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (111,683,333.43) | (21,483,333.47) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 328,959,459.76 | 251,120,660.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (207,817,038.20) | (57,746,193.87) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 94,957,124.00 | 104,908,349.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (71,595,603.99) | (9,603,732.53) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 986,032.00 | 1,976,032.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 22,316,754.29 | 27,265,000.00 |
| 39301 | Програм хангамж | 3,463,450.00 | 3,878,450.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,861,695.71) | (3,463,450.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 20,715,000.00 | 26,850,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **434,936,174.57** | **585,186,038.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **434,936,174.57** | **585,186,038.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 434,936,174.57 | 585,186,038.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 334,498,880.00 | 334,498,880.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 334,498,880.00 | 334,498,880.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (132,108,169.07) | 18,141,695.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (132,108,169.07) | (132,108,169.07) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 150,249,864.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 232,545,463.64 | 232,545,463.64 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **434,936,174.57** | **585,186,038.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,001,811,830.00** | **3,184,413,830.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,823,430.00** | **171,624,683.68** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 77,823,430.00 | 171,624,683.68 |
| 120009 | Бусад орлого | - | 66,890,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 77,650,730.00 | 103,764,583.68 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 172,700.00 | 970,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,923,988,400.00** | **3,012,789,147.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,923,988,400.00 | 2,915,353,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,923,988,400.00 | 2,915,353,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **97,435,347.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 97,435,347.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,951,238,742.58** | **3,034,163,966.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,951,238,742.58** | **3,034,163,966.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,941,951,056.53** | **2,800,419,318.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,508,996,783.13** | **2,170,257,025.26** |
| 210101 | Үндсэн цалин | 957,415,068.75 | 1,272,034,383.92 |
| 210102 | Нэмэгдэл | 351,861,350.31 | 651,008,446.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,766,400.00 | 134,415,595.67 |
| 210104 | Урамшуулал | 140,953,964.07 | 112,798,599.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **187,165,133.74** | **278,284,936.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 135,917,633.74 | 198,757,293.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,811,900.00 | 20,746,841.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,249,500.00 | 9,731,718.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,562,400.00 | 9,995,087.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,623,700.00 | 39,053,995.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **59,857,800.00** | **66,160,507.07** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,327,944.00 | 6,001,132.67 |
| 210302 | Түлш, халаалт | 52,412,032.00 | 57,813,358.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,117,824.00 | 2,346,016.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **84,115,389.52** | **126,109,193.55** |
| 210401 | Бичиг хэрэг | 30,886,150.00 | 54,364,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,760,740.00 | 31,369,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 18,628,779.52 | 30,306,513.55 |
| 210404 | Ном, хэвлэл | 115,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,544,720.00 | 9,069,050.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **500,000.00** | **1,596,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 1,596,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,106,902.00** | **56,595,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,101,000.00 | 13,454,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,005,902.00 | 43,141,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **21,263,050.00** | **16,256,750.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,263,050.00 | 16,256,750.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,129,557.56** | **19,228,426.45** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,804,814.56 | 14,016,265.45 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,087,225.00 | 3,100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,936.00 | 205,261.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 868,000.00 | 1,565,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 155,582.00 | 275,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,816,440.58** | **65,930,979.26** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 3,110,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,316,440.58 | 62,820,479.26 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,287,686.05** | **233,744,648.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,700,000.00 | 125,107,566.96 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 121,507,566.96 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,700,000.00 | 3,600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,587,686.05 | 108,637,081.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,587,686.05 | 108,637,081.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **50,573,087.42** | **150,249,864.42** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,646,239.67 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,646,239.67 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,646,239.67) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **48,926,847.75** | **150,249,864.42** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,936,588,400.00 | 3,012,789,147.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,600,000.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,600,000.00 | - |
| 140020 | Бусад орлого | 12,600,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,923,988,400.00 | 3,012,789,147.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,923,988,400.00 | 2,915,353,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,923,988,400.00 | 2,915,353,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 97,435,347.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 97,435,347.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,915,436,400.00 | 2,971,891,147.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,915,436,400.00 | 2,971,891,147.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,906,148,713.95 | 2,738,146,499.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,521,596,783.13 | 2,180,709,584.73 |
| 210101 | Үндсэн цалин | 970,015,068.75 | 1,271,139,134.00 |
| 210102 | Нэмэгдэл | 351,861,350.31 | 662,997,957.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,766,400.00 | 133,773,893.61 |
| 210104 | Урамшуулал | 140,953,964.07 | 112,798,599.57 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 187,165,133.74 | 267,196,077.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 135,917,633.74 | 187,026,732.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,811,900.00 | 20,746,841.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,249,500.00 | 10,373,420.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,562,400.00 | 9,995,087.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,623,700.00 | 39,053,995.94 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 59,857,800.00 | 65,862,226.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,327,944.00 | 5,616,852.33 |
| 210302 | Түлш, халаалт | 52,412,032.00 | 57,899,358.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,117,824.00 | 2,346,016.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 84,115,389.52 | 125,486,473.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 30,881,150.00 | 53,230,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,760,740.00 | 31,393,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 18,628,779.52 | 30,690,793.89 |
| 210404 | Ном, хэвлэл | 115,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,549,720.00 | 9,172,050.00 |
| 2105 | Нормативт зардал | 500,000.00 | 1,596,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 1,596,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,021,000.00 | 58,064,160.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,101,000.00 | 14,851,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,920,000.00 | 43,212,660.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 21,263,050.00 | 17,112,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,263,050.00 | 17,112,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 14,129,557.56 | 19,009,476.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,804,814.56 | 13,797,315.45 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,087,225.00 | 3,100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,936.00 | 205,261.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 868,000.00 | 1,565,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 155,582.00 | 275,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 3,110,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 3,110,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,287,686.05 | 233,744,648.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,700,000.00 | 125,107,566.96 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 121,507,566.96 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,700,000.00 | 3,600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,587,686.05 | 108,637,081.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,587,686.05 | 108,637,081.04 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 21,152,000.00 | 40,898,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 10,552,000.00 | 44,008,500.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,552,000.00 | 44,008,500.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10,552,000.00 | 44,008,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,552,000.00 | 44,008,500.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (10,552,000.00) | (44,008,500.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 10,600,000.00 | (3,110,500.00) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 10,600,000.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 334,498,880.00 | 232,545,463.64 | -181,035,016.82 | 386,009,326.82 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **334,498,880.00** | **232,545,463.64** | **-181,035,016.82** | 386,009,326.82 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 48,926,847.75 | 48,926,847.75 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **334,498,880.00** | **232,545,463.64** | **-132,108,169.07** | 434,936,174.57 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **334,498,880.00** | **232,545,463.64** | **-132,108,169.07** | 434,936,174.57 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **334,498,880.00** | **232,545,463.64** | **-132,108,169.07** | 434,936,174.57 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 150,249,864.42 | 150,249,864.42 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **334,498,880.00** | **232,545,463.64** | **18,141,695.35** | 585,186,038.99 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,019,753,800.00 | 2,806,728,835.39 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,019,753,800.00 | 2,806,728,835.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,787,183,300.00 | 2,681,621,268.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,182,080,700.00 | 2,089,640,465.16 |
| 210101 | Үндсэн цалин | 1,406,466,900.00 | 1,271,139,134.00 |
| 210102 | Нэмэгдэл | 557,834,900.00 | 571,928,837.98 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 150,414,000.00 | 133,773,893.61 |
| 210104 | Урамшуулал | 67,364,900.00 | 112,798,599.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 271,760,100.00 | 260,841,966.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 193,196,900.00 | 180,672,621.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,640,800.00 | 20,746,841.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,820,400.00 | 10,373,420.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,820,400.00 | 9,995,087.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,281,600.00 | 39,053,995.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,864,700.00 | 65,862,226.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,590,000.00 | 5,616,852.33 |
| 210302 | Түлш, халаалт | 57,904,300.00 | 57,899,358.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,370,400.00 | 2,346,016.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 128,085,200.00 | 127,906,473.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 53,961,000.00 | 53,230,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,809,200.00 | 31,393,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 29,220,000.00 | 30,690,793.89 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 990,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,095,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,000,000.00 | 10,602,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,600,000.00 | 1,596,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,600,000.00 | 1,596,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 98,880,000.00 | 98,537,660.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 31,170,000.00 | 31,100,500.00 |
| 210602 | Тавилга | 19,500,000.00 | 19,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 48,210,000.00 | 47,937,160.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,450,000.00 | 17,112,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,450,000.00 | 17,112,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,462,600.00 | 20,124,476.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,784,000.00 | 14,497,315.45 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,100,000.00 | 3,100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 210,000.00 | 205,261.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,500.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,980,500.00 | 1,980,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 277,600.00 | 275,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 232,570,500.00 | 125,107,566.96 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 232,570,500.00 | 125,107,566.96 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 104,400,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 124,370,500.00 | 121,507,566.96 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,800,000.00 | 3,600,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,019,753,800.00 | 2,806,728,835.39 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,019,753,800.00 | 2,806,728,835.39 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,019,753,800.00 | 2,806,728,835.39 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 43.00 | 44.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 5.00 | 5.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 25.00 | 25.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | 1.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **43.00** | **44.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 18.00 | 18.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 13.00 | 13.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 12.00 | 12.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | 1.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **97,423,230.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **97,423,230.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 97,423,230.57 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 91,069,119.57 |
| 210101 | Үндсэн цалин | |
| 210102 | Нэмэгдэл | 91,069,119.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,354,111.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,354,111.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **97,423,230.57** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **97,423,230.57** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,423,230.57 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүн таслах ажиллагааны хэвийн байдлыг хангах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллага юм.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь “Шүүхийн хараат бус байдлыг хангахтай холбоотой болон иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх, шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах” гэсэн зорилго дэвшүүлсэн ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Шүүхийн тамгын газар нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2024 онд дотоод аудитын шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 11 сарын 11-ны өдрийн 215 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 150.2 сая төгрөгөөр буюу 34.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,600.00 | 7,489.50 | -3,110.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 0.00 | 0.00 | 0.0 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.0 |
| Бараа материал | 4,379.70 | 5,897.46 | 1,517.8 |
| Үндсэн хөрөнгө | 419956.47 | 571799.08 | 151,842.6 |
| **Нийт хөрөнгө** | **434,936.17** | **585,186.04** | **150,249.9** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 434,936.17 | 585,186.04 | 150,249.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **434,936.17** | **585,186.04** | **150249.9** |

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэнд 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй бай оны эцэст 7.5 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй гарсан ба 3.1 сая төгрөгийн ахмадын санд зарцуулсан байна.

Авлага, урьдчилгаа дансанд өөрчлөлт гараагүй. Бараа материалын дансанд бага дүнтэй, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс оны эхэнд 4.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр нийт 125.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1.0 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй хүлээн авч, 124.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 5.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 419.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 44.0 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, 6.1 төгрөгийн газрын сайжруулалт хийж, 14.8 сая төгрөгийн аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 тоот захирамжаар Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн авч, 88.9 сая төгрөгийн хөрөнгийн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс үнэ төлбөргүй хүлээн авч, 20.0 сая төгрөгийн УАЗ-31519 маркийн автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж, 168.4 сая төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 767 тоот тогтоолоор акталж, 62.8 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл байгуулж, оны эцэст 571.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Өглөг дансны оны эцэст өглөггүй гарсан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 150.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 2,323.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 570.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 125.8 сая төгрөгөөр нийтдээ 696.6 сая төгрөгөөр нэмж, нийт төсвийг 3,019.7 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 696.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,019.7 сая төгрөгөөр тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,806.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжилт авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,057.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 33.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,806.7 сая төгрөг буюу 92.9 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 108.6 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,783,483.3 | 2,678,341.9 | 105,141.4 | 96.2% |
| 2 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 2,500.0 | 2,488.1 | 11.9 | 99.5% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 232,570.5 | 125,107.6 | 107,462.9 | 53.8% |
| 4 | Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал | 1,200.0 | 791,2 | 408,8 | 65.9 |
| | **Дүн** | **3,019,753.8** | **2,806,728.8** | **213,025.0** | **92.9** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна.Үүнд:

Шүүхийн тамгын газрын Ахмадын сангийн дансны оны эхний үлдэгдэл 10.6 сая төгрөг ба цалингийн сангаас 3.1 сая төгрөг төвлөрүүлж тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудад 3.1 сая төгрөгийн түлээ, нүүрсний мөнгө олгож, оны эцсийн үлдэгдэл 7.5 сая төгрөг байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 26.5 сая төгрөгийн хөрөнгийг шууд гэрээгээр, 9.2 сая төгрөгийн хөрөнгийг харьцуулалтын аргаар тендер зарлаж худалдан авалт хийсэн байна.

Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн төсвөөс /210801/ 13.8 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс /210901/ 3.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Шүүхийн тамгын газарт 2024 онд 43 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 5, гүйцэтгэх ажилтан 25, үйлчлэх ажилтан 13, гэрээт ажилтан 1 нийтдээ 44 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн тамгын газар нь тайлант онд 97.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 97.4 сая төгрөгийг зарцуулж, 0.01 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 45 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,951.2 сая төгрөгөөс буюу 29.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Нэмэгдэл цалин, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг нийтдээ 108.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 2.784.5 сая төгрөгийн 25 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 207.9 сая төгрөгийн 24 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 83.7 сая төгрөгийн 18 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 108.6 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулга хийсэн.Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт 108.6 сая төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнасныг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТГТ-д эх үүсвэрийг зөрүүтэй тайлагнасан | 1 | 108,624.9 | | | 1 | 108,624.9 | 1 | 108,624.9 | | | | |
| **Дүн** | **1** | **108,624.9** | | | **1** | **108,624.9** | **1** | **108,624.9** | | | | |

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн цахим худалдан авалтын журам зөрчсөн | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |